



УЛААНБААТАР
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

1987 оны 8
сарын 18 өдөр

Дугаар 236

Улаанбаатар
хот

Ясли, цэцэрлэгийн комбинатууд,
цэцэрлэгийн салбар нээж ажил-
луулах тухай

Улаанбаатар хотын АХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Ардын боловсролын удирдах газар /н. Батмагнай/-т зөвшөөрөх.

а/Октябрийн районы I, X хороололд ашиглалтад орсон 280 ортой ясли, цэцэрлэгийн комбинатуудад II0, III, II2, II3, II4, Найрамдлын район, Гачуурт, Партизаны хороонд ашиглалтад орсон I40 ортой ясли цэцэрлэгийн комбинатуудад II5, 63, II6 гэсэн дугаарууд тус тус өгч нээж ажиллуулах;

б/Хотын Архитектур төлөвлөлтийн газрын Барилга архитектур хяналтын алба, улсын ариун цэвэр, халдвар судлалын байцаан шалгах газрын байцаагч нарын гаргасан дүгнэлт актыг үндэслэн Био комбинатын 29 дүгээр цэцэрлэгийн 23,0 мянган төгрөгийн үнэтэй барилыг үндсэн хөрөнгөнөөс хасах;

в/шинээр ашиглалтад орсон Октябрийн районы II0, III, II2, II4, Найрамдлын районы II5, Гачуурт, Партизаны хорооны 63, II6 дугаар ясли, цэцэрлэгийн комбинатуудад хэрэглэх бичгийн нүүр, тэмцгийг зохих журмын дагуу холбогдох газруудад захиалан хийлгэж хэрэглүүлэх:

2. Ардын боловсролын удирдах газар /н. Батмагнай/, Эрүүлийг хамгаалах газар /н. Бямбаа/-т даалгах нь:

а/Гачууртын төвд I40 ортой ясли цэцэрлэгийн комбинат ашиглалтад орсонтой холбогдуулж одоо ажиллаж буй 9 дүгээр ясли /35 ортой/, 63 дугаар цэцэрлэг /75 ортой/-ийг уг шинэ барилгад шилжүүлэн цэцэрлэгийн I00, яслийн 50 ортойгоор ажиллуулж, түүний харьяа 25 ортой холимог бүлгийг Шархоолойн фермд шинээр нээж ардын боловсролын системд ажиллуулсугай;

б/Гачуурт хорооны цэцэрлэгийн ашиглаж байсан байрыг тус хорооны I0 жилийн дунд сургуульд дотуур байрны зориулалтаар

2.

ашиглуулсугай;

в/Партизан хороонд 140 ортой ясли цэцэрлэгийн комбинат ашиглалтад орсонтой холбогдуулж төвийн 38 дугаар ясли /30 ортой/ 74 дүгээр цэцэрлэг /75 ортой/-ийг уг шинэ барилгад шилжүүлэн тус комбинатын яслийг 60 ортой, цэцэрлэгийг 80 ортой, Нарийн фермийн 25 ортой бүлгийг уг комбинатын харьяанд ажиллуулсугай;

г/Партизан хорооны хуучин цэцэрлэгийг 50 ортойгоор, Ар гүнт, Шижирийн бригадад тус бүр 25 ортой холимог бүлгийг тус комбинатын харьяанд 1988 оны I дүгээр сарын I-нээс эхлэн шинээр нээж ажиллуулсугай.

3.Био комбинат дахь 29 дүгээр цэцэрлэгийг Ажилчны районы 13 дугаар хорооны орон сууцны 53 дугаар байранд 3 айлын сууц түр чөлөөлөн оруулж, байраа өгсөн хүмүүст энэ оны 9 дүгээр сард ашиглалтад орох орон сууцнаас хуваарилж олгохыг Орон сууц, нийтийн үйлчилгээний хэлтэс /н.Зул/-т даалгасугай.

4.Шинээр ашиглалтад орсон дээрх ясли, цэцэрлэгийн комбина-туудын орон тоо, төсвийг баталж санхүүжүүлэхийг Санхүүгийн хэлтэс /н.Гонгор/-т даалгасугай.

5.Био комбинатад 1990 онд барихаар төлөвлөгөөнд тусгагдсан 140 ортой ясли, цэцэрлэгийн комбинатын барилгыг 1988 онд эхлүүлэх талаар холбогдох газруудад асуудал тавьж шийдвэрлүүлэхийг Ардын боловсролын удирдах газар /н.Батмагнай/, Төлөвлөгөөний комисс /н.Ганбаатар/, Их барилгын хэлтэс /н.Нэргүй/-т даалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АЛХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА

УЛААНБААТАР ХОТЫН АЛХ-ЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ХАРИУЦ-
ЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

[Signature]

С.МОНХЖАРГАЛ

[Signature]

Д.АЛГИА